

**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ
ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН
ЗОРИЛТЫН 2021 ОНЫ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
/Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар/**

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	Дүүргийн ЗДТГ-аас хороодын албан хаагчдад зориулан Хууль, эрх зүйн мэдлэг олгох 2 удаагийн багц сургалт, Эерэг харицаа ба хандлага сэдэвт багц сургалтыг зохион байгуулж 270, НЗДТГ-ын 18 удаагийн сургалтад 90, ЗГ-ын ХЭГ-ын 1 удаагийн сургалтад 93, НАГ-ын 2 удаагийн сургалтад 2, ТАЗ-ийн 2 удаагийн сургалтад 5, ХНХЯ-ны 1 сургалтад 5, Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 6, чиглүүлэх богино хугацааны сургалтад 10, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2, дунд хугацааны давтан сургалтад 1, мэргэжил дээшлүүлэх магистрийн хөтөлбөрт 7 албан хаагчийг тус тус хамруулсан. Нийт давхардсан тоогоор 484 албан хаагч сургалтад хамрагдсан байна. Мэдээллийн цагийг 2 удаа зохион байгуулсан.	48,685,8	Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдал, Өндөржүүлсэн бэлэн байдалд зарласантай холбогдуулан зарим сургалт зохион байгуулагдаагүй.
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Албан хаагчдын 100 хувь хамрагдсан.	100%	
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	БНХАУ-ын Бээжингийн Хятад хэл соёлын коллежоос зохион байгуулсан Хятад улсын хэл, соёлын талаарх цахим сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Дэлхий нийтэд шинэкорона вируст (Ковид-19) халдвар тархсантай холбогдуулан гадаад сургалтууд цуцлагдаж, тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.	50%	
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний	3 болон түүнээс дээш жил ажилласан	70 хувиас дээш	Засаг даргын Тамгын газар 2021 оны жилийн эцсийн байдлаар 156 орон тоотой байхаас 145 албан		100%

		нөөцийг бүрдүүлэх	мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт		хаагчтай ажиллаж байна. Үүнээс 3 болон түүнээс дээш жил ажилласан албан хаагчдын тоо 113 буюу 77,9 хувьтай байна.		
	Хэсгийн дундаж:						83,3%
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэл ээр	Хамтран ажиллах, хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн тайланг хагас жилээр үнэлж дүгнэн 138 албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон. Монгол улсын төрийн одон медалиар шагнагдсан 14 албан хаагчийг 1 сарын үндсэн цалингаар урамшуулсан. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нэг хаалганг шинжилгээ арга хэмжээнд сайн ажилласан 45 албан хаагчийг албан тушаалын үндсэн цалингийн 10-15 хувиар, нийслэлийн Аудитын газрын санхүүгийн нэгдсэн тайланд стандарт, зөрчилгүй үнэлгээ авсан 6 албан хаагчийг албан тушаалын 3 сарын үндсэн цалингаар тус тус шагнаж урамшуулсан.		100%
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэл ээр	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/452 дугаар захирамжаар 32 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгосон. Үүнээс 5 албан хаагчид шинээр зэрэг дэв олгосон байна.		100%
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Ажлын байрны таатай орчин бүрдүүлсэн эсэх талаар албан хаагчдаас 8 асуулт бүхий сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан албан хаагчдын ажлын байрны таатай нөхцлийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ 95% нь "Маш сайн" гэсэн үнэлгээ өгсөн байна.		100%
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэл ээр	Албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтөд 1 хоногт 13000 төгрөг олгож байна.		100%

5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Шинэкоронавирусийн халдвараас сэргийлж албан хаагчдыг шаардлагатай ариутгал, халдваргүйжүүлэгч бодис, маск, эм, эмнэлгийн хэрэгслэл, дархлаа дэмжих бүтээгдэхүүнээр хангасан. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг 2021 оны 09 дүгээр сард зохион байгуулж, 62 хамрагдаж, дархлаа дэмжих багцийг 85 албан хаагчид олгосон.	39,110,0	100%
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	Засаг даргын Тамгын газар, хороодын 147 албан хаагч бүрэн хамрагдсан.		100%
	Хэсгийн дундаж:					100%
Үнэлгээний дундаж хувь:						91,6%